



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/21

Мэргэн хошуу

Сумын алдарт уяач
цол олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Үндэсний баяр наадмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2 дугаар багийн уяач Содномдашийн Алтанзул Аймгийн бүсийн 1 түрүү, Сумын баяр наадмын 5 түрүү, 12 айраг, 4 дүгээр багийн уяач Пүрэвийн Баттүвшин Сумын баяр наадмын 4 түрүү, 5 айраг, 1 дүгээр багийн уяач Жамъянхоролын Оюунболд Сумын баяр наадмын 3 түрүү, 7 айраг, 1 дүгээр багийн залуу уяач Алтанцэцэгийн Төрболд сумын баяр наадмын 3 түрүү, 6 айраг хүртсэн амжилтаар сумын "Алдарт уяач цол" тус тус олгосугай.

2. "Алдарт уяач" цолны тэмдэг, үнэмлэх олгохыг Дархан-Ажнай морин спорт уяачдын холбооны тэргүүн (С.Амарболд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТБОЛД